

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ АЖЛЫН ХЭСГИЙН 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ
ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ТОЙМ**

Тус Байнгын хорооны 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагт Төрийн ордны “Г” танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Я.Содбаатар, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Д.Батцогт, Ё.Отгонбаяр, Д.Сарангэрэл, Д.Хаянхярваа, Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн хуулийн зөвлөх Ө.Хонгорзул, Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Удирдлага, зохицуулалтын газрын дарга Ж.Пүрэвжав, Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгч Б.Гүнбилэг, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Ажлын албаны зөвлөх Ж.Чимгээ, референт А.Болортуяа нар оролцлоо.

Хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Я.Содбаатар удирдаж, зарчмын зөрүүтэй болон найруулгын чанартай саналын томьёоллыг нэгбүрчлэн хэлэлцлээ.

Ажлын хэсгийн хуралдаан 10.45 цагт өндөрлөв.

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны
ажлын алба**